



МОНГОЛ УЛС  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20 **10** он **09** дугаар  
сарын **30**-ны өдөр

Дугаар **1288**  
**/2328**

Улаанбаатар-12  
Утас: 260817  
Факс: 976-11-310011

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА  
Г.ЗАНДАНШАТАР ТАНАА

Ерөнхий сайдын мэдээллийн тухай

Улсын Их Хурлын намрын ээлжит чуулганы 2020 оны 10 дугаар сарын 2-ны өдрийн нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн намрын ургац хураалт болон өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын явцын талаар хийх мэдээллийг хүргүүлэв.

Хүндэтгэсэн,

Монгол Улсын сайд,  
Засгийн газрын Хэрэг  
эрхлэх газрын дарга

Л.ОЮУН-ЭРДЭНЭ



2056219

**УЛСЫН ИХ ХУРЛЫН 2020.10.02-НЫ ӨДРИЙН ЧУУЛГАНЫ НЭГДСЭН  
ХУРАЛДААНД МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД У.ХҮРЭЛСҮХИЙН  
НАМРЫН УРГАЦ ХУРААЛТ БОЛОН ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛТГЭЛ  
ХАНГАХ АЖЛЫН ЯВЦЫН ТАЛААР ХИЙХ МЭДЭЭЛЭЛ**

**Нэг.Ургац хураалтын ажлын явцын талаар**

2020 оны ургацын урьдчилсан балансаар 513 мянган тонн үр тариа, үүнээс 487 мянган тонн улаанбуудай, 237 мянган тонн төмс, 113 мянган тонн хүнсний ногоо, 33 мянган тонн тосны ургамал, 109 мянган тонн малын тэжээлийн ургамал тус тус хураан авч, гурил үйлдвэрлэлд нийтдээ 398 мянган тонн буудай нийлүүлэх боломжтой гэсэн төлөв гарсан.

Улаанбуудайн болц, цаг агаарын төлөв байдлаас шалтгаалан урьдчилсан балансаар гурил үйлдвэрлэлд нийлүүлэх боломжтой улаанбуудайн хэмжээг 20 орчим хувиар бууруулж тооцоход, гурил үйлдвэрлэлд 318.4 мянган тонн хүнсний улаанбуудай нийлүүлэхээр байна.

Манай улсын жилийн хэрэгцээт гурилыг дотооддоо үйлдвэрлэхэд 306 мянган тонн цэвэр хүнсний улаанбуудай, түүнчлэн 180 мянган тонн төмс, 251 мянган тонн хүнсний ногоо шаардлагатай бөгөөд балансаас хараад улаанбуудай, төмсний хэрэгцээгээ бүрэн, гол нэрийн хүнсний ногооны 60 орчим хувь, бага тархацтай ногооны 45 хувийг тус тус дотоодын ургацаас хангах боломжтой байна.

Ургацын урьдчилсан төлөвийг өнгөрсөн оны ургацын дүнтэй харьцуулбал хураан авах улаанбуудай 80 мянган тонн, төмс 46.2 мянган тонн, хүнсний ногоо 19 мянган тонноор илүү байхаар байна.

2020 оны 9 дүгээр сар бүхэлдээ хур бороо ихтэй байснаас ихэнх бүс нутагт ургац хураалтын ажил эхлэлийн шатандaa байгаа бөгөөд техникийн хүчин чадлын тооцооллоор технологийн 20-25 хоногт багтаан ургац хураалтын ажлыг зохион байгуулахаар ажиллаж байна.

Улсын хэмжээнд ургац хураалтын бэлтгэлийг бүрэн хангасны үндсэн дээр ургацыг хяруу, хүйтрэлтээс хамгаалах, ангилан хадсан тарианы мөрийг эргүүлэх, хатаах төхөөрөмж бэлтгэх, үтрээмийн техникийн ашиглалтыг сайжруулах, хураалтад ажиллах оюутан, цэргийн алба хаагчдын аюулгүй ажиллагаа, байр, цалин урамшууллын асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн шат дараатай арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

2020 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн байдлаар 45.3 мянган га талбайг ангилан хадаж нийтдээ 77.9 мянган га-гаас 101.8 мянган тонн үр тариа, үүнээс 95.7 мянган тонн улаанбуудай, 13.8 мянган га-гаас 183.5 мянган тонн төмс, 5.4 мянган га-гаас 64.7 мянган тонн хүнсний ногоо тус тус хураан авснаар үр тарианы хураалт 20.3 хувь, хүнсний ногооны хураалт 56.8 хувь, төмсний хураалт 74.3 хувь, тэжээлийн тарималын хураалт 22.5 хувийн явцтай байна.

Төмс, хүнсний ногооны борлуулалтыг дэмжих зорилгоор “Намрын ногоон өдрүүд” нэгдсэн арга хэмжээг Улаанбаатар хотод зохион байгуулж, 9 дүүргийн 45 байршилд шинэ ургацын төмс, хүнсний ногоо худалдан борлуулж байна.

Мөн тариаланчдад 150 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгох асуудлыг бүрэн шийдвэрлэж, арилжааны банкуудаар дамжуулан олгож эхэлсэн.

Цаг агаарын урьдчилсан мэдээгээр 2020.10.03-2020.10.20-ны өдрүүдэд тариалангийн бус нутгуудаар цаг агаар тогтворжиж, ургац хураалтыг хэвийн явуулах боломж бүрдэж байгаа тул энэ хугацааг үр дүнтэй ашиглаж, ургац хураалтын ажлаа эрчимжүүлэх, тариаланчид болон холбогдох төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдааг хангаж ажиллахад анхаарч байна.

### **Хоёр.Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын явцын талаар**

Мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл хангах чиглэлээр Засгийн газар “Хөдөө аж ахуйн салбарын 2020-2021 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” 19 дүгээр тогтоолыг гаргаж, бүх шатанд хэрэгжилтийг эрчимтэй хангуулан ажиллаж байна.

#### **2.1.Бэлчээрийн ургамлын ургалтын талаар:**

Манай орны бэлчээрийн ургамлын ургалтын байдал 2020 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн байдлаар нийт нутгийн 56 хувьд “сайн”, 31 хувьд “дунд”, 13 хувьд “харьцангуй муу” гэсэн үнэлгээтэй байна.

Говь-Алтай аймгийн 17; Өвөрхангай аймгийн 6; Төв аймгийн Лүн; Дундговь аймгийн Дэлгэрхангай; Өмнөговь аймгийн 5 суманд бэлчээрийн ургамлын байдал харьцангуй муу байна.

Энэ зүн нийт нутгийн 70 гаруй хувьд олон жилийн дундаж орчим буюу түүнээс ахиу; харин Баянхонгор, Өвөрхангай, Говь-Алтай, Өмнөговь аймгийн ихэнх; Дундговь, Хөвсгөлийн зарим нутгаар дунджаас бага тунадас орсон.

Энэ оны 5 дугаар сард ихэнх нутгаар сэргүүн буюу дулаан дутсанаас бэлчээрийн ургамлын ургалт удааширсан, 7 дугаар сараас зуншлага сайжирсан боловч Баянхонгор, Дундговь, Өвөрхангай, Говь-Алтай, Өмнөговь аймгийн ихэнх нутгаар гантай байлаа.

Цаг уур, орчны шинжилгээний газрын ирүүлсэн мэдээллээр 2020-2021 оны өвөл, хаврын бэлчээрийн даац нийт бэлчээрийн 50.6 хувьд хүрэлцээтэй, 25 хувьд 1-3 дахин, 6.1 хувьд 3-5 дахин, 18.3 хувьд олон дахин хэтэрсэн байна.

Ялангуяа Говь-Алтай аймгийн 7 сум, Баянхонгор аймгийн 15 сум, Өвөрхангай аймгийн 7 сум, Дундговь аймгийн 8 сум, Өмнөговь аймгийн 8 сумын бэлчээрийн даац “олон дахин хэтэрсэн” дүн гарчээ.

2020 оны 8 дугаар сарын дундаас хойш бүх нутгаар үргэлжлэн орсон бороо, хадлан тэжээл бэлтгэхэд хүндрэл учруулж байгаа бөгөөд цаашид цас орж хүйтэрвэл мал өвөлжилт хүндрэх эрсдэл үүсэхээр байна.

#### **2.2.Отор нүүдлийн талаар:**

Аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газраас ирүүлсэн улсын тусгай хамгаалалттай газар, хилийн зурvas газар, улсын тусгай хэрэгцээний аймаг

дундын 9 отрын бүс нутаг, орон нутгийн тусгай хэрэгцээний отрын нөөц нутагт отроор өвөлжиж, хаваржих малчин өрх, малын тооны судалгааг нэгтгэвэл:

-улсын тусгай хамгаалалттай газарт 7544 өрхийн 3.1 сая толгой мал;

-хилийн зурvas газарт 3539 өрхийн 1.3 сая толгой мал;

-улсын тусгай хэрэгцээний аймаг дундын отрын бүс нутагт 2685 өрхийн 2.4 сая толгой мал;

-орон нутгийн тусгай хэрэгцээний отрын нөөц нутагт 2658 өрхийн 1.5 сая толгой мал буюу нийт 16426 өрхийн 8.35 сая толгой малыг отроор өвөлжүүлж, хаваржуулах хүсэлт иржээ.

Эдгээр хүсэлтийн хүрээнд улсын тусгай хамгаалалттай газар болон хилийн зурvas газрын бэлчээрийн даацаад тохирсон тооны малыг отроор өвөлжүүлж, хаваржуулах арга хэмжээг шуурхай зохион байгуулж, мал аж ахуйн салбарын эрсдэлийг даван туулах чадавхыг нэмэгдүүлэн өвлийг өнтэй давах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Дээр дурдсан аймаг дундын 9 отрын бүс нутаг нь хонин толгойд шилжүүлснээр нийт 724.5 мянган толгой малын бэлчээрийн даацтай боловч аймгуудаас 3 дахин их буюу 2.4 сая толгой малыг оторлуулах хүсэлт ирүүлсэн. Иймд тэргүүн ээлжид зуншлага тааруу байсан аймгуудын малыг хуваарилан оруулах зохицуулалт хийхээр төлөвлөсөн болно.

### 2.3.Хадлан тэжээл бэлтгэлийн талаар:

Өвс, тэжээлийн дотоодын нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор хивэгний экспортыг 2020.09.21-2021.04.01-ний өдрийг хүртэлх хугацаанд түр хязгаарлах арга хэмжээ авсан бөгөөд үр дүнд 60 гаруй мянган тонн хивгийг мал аж ахуйн өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангахад нийлүүлэх боломж бүрдэж байгаа.

Энэ хүрээнд гурил үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдтэй хивэг худалдан авах гэрээ байгуулж, аюулгүй нөөцийн хивгээ шуурхай татан төвлөрүүлэх, хивэгний зохиомол хомсдол үүсгэхгүй байх, үнийн тогтвортой байдлыг хадгалах чиглэлээр шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Засаг дарга наарт үүрэг болгосон.

Мөн Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Булган, Сэлэнгэ аймгийн Засаг дарга наарт говийн болон хадлангийн нөөц багатай аймгуудыг өөрийн аймагт хадлан бэлтгэх боломжоор хангах, бодлогын гэрээ байгуулан ажиллах тухай үүрэг өгч хэрэгжилтийг ханггуулан ажиллаж байна.

2020 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар аймаг, сумын аюулгүй нөөцөд 4.8 мянган тонн өвс, 960.3 тонн тэжээл; малчдын түвшинд 581 мянган тонн өвс, 212 тонн сүрэл, 7.6 мянган тонн ногоон тэжээл, 1.3 мянган тонн үйлдвэрийн тэжээл, 9.5 мянган тонн гар тэжээл, 22.1 тонн дарш, 11.1 мянган тонн хужир, шүү тус тус бэлтгээд байна.

### 2.4.Бэлчээрийн усан хангамжийн талаар:

2020 онд бэлчээрийн усан хангамжийг сайжруулах ажлын хүрээнд улсын болон орон нутгийн төсөв, төсөл, хөтөлбөрийн хөрөнгө оруулалтаар 21 аймгийн 241 суманд 407 худгийг шинээр байгуулж, 130 худгийг сэргээн засварласан.

Газрын доорх усны хайгуул судалгааны ажлыг Булган, Завхан, Хөвсгөл, Төв, Өмнөговь, Өвөрхангай, Дорнговь, Дорнод, Баян-Өлгий, Говь-Алтай, Увс аймгийн 280 гаруй бэлчээрийн талбайд хийжээ.

#### 2.5.Малын эрүүл мэндийн талаар:

Мал сүргийг эрүүлжүүлэх, дотоодын үйлдвэрийг малын гаралтай чанартай түүхий эдээр хангах зорилгоор мал угаалгын арга хэмжээг нэгдсэн төлөвлөгөө гарган зохион байгуулан ажиллаж байна.

Д/д	Арга хэмжээний нэр	Төлөвлөгөө /сая.тол/	Гүйцэтгэл /сая.тол/	Гүйцэтгэл хувиар
1.	Угаалга	66.2	47.7	72.0
2.	Туулга	13.5	12.9	95.8
3.	Боловсруулалт	6.6	5.8	88.4
4.	Үхрийн арьсны гуурын боловсруулалт	4.7	4.1	87.0
	Бүгд	91.0	70.5	76.3

Шимэгчтэх өвчинеэс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд 70.5 сая толгой мал сүргийг хамруулж, гүйцэтгэл 76.3 хувтай байна.

Малын эрүүл мэндийн үзлэгийн арга хэмжээнд 70.4 сая толгой мал сүргийг хамруулахаар төлөвлөснөөс 9 дүгээр сарын байдлаар 51 сая толгой буюу мал сүргийн 72.4 хувийг хамруулаад байна.

#### 2.6.Хэрэгцээлэх малын судалгаа:

Манай улсын 112 сая га хадлан, бэлчээрийн талбайд 2020 оны 9 дүгээр сарын байдлаар 90 сая орчим толгой мал бэлчээрлэж байна. Үүнээс Архангай, Хөвсгөл, Өвөрхангай аймагт 22.4 сая толгой буюу нийт малын 24 орчим хувь ногдож байна.

Малыг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг малын төрөл, сүргийн зохистой харьцаанд тулгуурлан зохион байгуулах, ялангуяа малыг өсвөр насанд нь аль болох богино хугацаанд тарга, хүч сайн авахуулсны үндсэн дээр бага зардал гаргаж түргэн борлуулахад анхаарч ажиллаж байна.

2020 онд бойжуулсан 22.7 сая толгой төл, бэлчээрийн даац хэтэрсэн аймгууд болон газар тариалан эрхлэх бус нутгаар зарласан аймгуудын өнгөрсөн оны эцэст тоологдсон малын 10 хүртэл хувийг зах зээлд нийлүүлэхээр тооцож нийт малын 28 орчим хувь буюу 25 сая толгой малыг эдийн засгийн эргэлтэд оруулах боломжтой гэж төлөвлөөд байна.

Дотоодын хүн амын хүнсний хэрэгцээнд 10-12 сая толгой, экспортод 13-15 сая толгой малыг (3 сая хүртэл толгой малыг амьдаар) нийлүүлэх боломжтой юм.

Өөрөөр хэлбэл малчид ирэх өвөл, хаврыг малын зүй бус хорогдолгүй өнтэй даван туулахын тулд малын тоог бэлчээрийн даацаад тохируулах, отроор мал өвөлжиж, хаваржих газруудын бэлчээрийн даацаас хэтрэхгүй тооны малыг

оторлуулах, бүх түвшинд аюулгүй нөөцийн өвс, тэжээлийг хангалттай бэлтгэх шаардлагатай байна.

## 2.7. Мал, мах бэлтгэх, махны нөөц бүрдүүлэх талаар:

Нийслэлийн хүн амын өвөл, хаврын махны хангамж, үнийг тогтвортой байлгахад анхаарч, 20 мянган тонноос багагүй хэмжээний махны нөөц бүрдүүлэхээр бэлтгэл ханган ажиллаж байна.

Энэ хүрээнд Засгийн газрын 2020 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанаар нийслэлийн хүн амын өвөл, хаврын улирлын хүнсний хэрэгцээнд зориулан арилжааны банкны зээлээр мал, мах бэлтгэх аж ахуйн нэгжид олгох зээлийн хүүгийн хөнгөлөлтийг 12 хүртэл сарын хугацаатай, 11 хувьтай байхаар тогтоов.

## Гурав. Төв, суурин газрын өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын явцын талаар

Төв, суурин газрын эрчим хүчиний нэгдсэн системийн найдвартай ажиллагааг хангах зорилгоор их болон урсгал засварын ажлыг шуурхай зохион байгуулах, өвлийн их ачааллыг хүндрэлгүй давах, өвөлжилтийн явцад гарах хүндрэлийг шуурхай зохицуулж, бэлэн байдлыг хангахад онцгой анхаарал хандуулж байна.

Энэ хүрээнд Засгийн газар “Төв, суурин газрын 2020-2021 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай” 69 дүгээр тогтоолыг гаргаж, бүх шатанд хэрэгжилтийг хангуюлан ажиллаж байна.

### 3.1. Эрчим хүчиний салбарын чиглэлээр:

2020 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн байдлаар эрчим хүчиний үйлдвэр, компаниудын өвөлжилтийн бэлтгэл ажил дунджаар 85.3 хувь, санхүүжилт 61.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

Харин нүүрсний уурхайнуудын өвөлжилтийн бэлтгэл ажлын гүйцэтгэл Багануурт 82 хувь, Шивээ-Овоод 81.6 хувь, Шарын голд 76 хувьтай байна.

Дулааны цахилгаан станцын үндсэн тоноглол болох 63 зуух, 43 турбингенератороос өнөөдрийн байдлаар ажилд 33 зуух, 31 турбингенератор, бэлтгэлд 19 зуух, 8 турбингенератор, засварт 11 зуух, 4 турбингенератор байгаа бөгөөд системийн горим ажиллагаа хэвийн байна.

Төвлөрсөн хот, суурин газруудын хэрэглэгчдийн шугам, сүлжээ гэмтэлтэй, засвар үйлчилгээ дуусаагүй байгаа тул халаалт залгалт 2020 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн байдлаар 90 орчим хувийн гүйцэтгэлтэй байна.

Одоогоор аймгийн төвүүдийн дулааны цахилгаан станц, халаалтын зуухны газруудын өвөлжилтийн бэлтгэл хангах засвар, шинэчлэлийн ажлын явц 70 орчим хувийн гүйцэтгэлтэй байна.

Цаашид өвлийн их ачааллын горим ажиллагааг хүндрэлгүй даван туулахын тулд “ДЦС-4” ТӨХК-ийн хүчин чадлыг 46 МВт, “Эрдэнэтийн ДЦС” ТӨХК-ийн хүчин чадлыг 35 МВт-аар тус тус нэмэгдүүлж, бусад үйлдвэр, дамжуулах, түгээх

сүлжээний засвар, шинэчлэлтийн ажлуудыг хугацаанд нь дуусгахаар төлөвлөж байна.

### 3.2.Боловсрол, эрүүл мэндийн салбарын чиглэлээр:

Боловсролын салбарын хувьд 36 сургууль, 27 цэцэрлэг, 10 дотуур байр, орон нутагт 3, нийт 73 их засварын ажлыг 20.6 тэрбум төгрөгөөр хийж гүйцэтгэсэн бол 8.6 тэрбум төгрөгийн 27 их засварын ажил үргэлжлэн хийгдэж байна.

Эрүүл мэндийн салбарын хувьд 2020 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 12.8 тэрбум төгрөгийн 57 ажлыг хийж гүйцэтгэж байна. 2020 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн байдлаар 16 аймгийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо, эмчилгээний төв болон нийслэлийн 3 дүүргийн эрүүл мэндийн байгууллага, тэдгээрийн харьяа 7 байгууллагын засвар шинэчлэлийн ажлын гүйцэтгэл 92.3 хувьтай байна.

### **Дөрөв.Нийслэлийн 2021-2020 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын явцын талаар**

#### 4.1.Цахилгаан, дулаан усан хангамжийн талаар:

Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд нийслэлийн цахилгаан дулааны эх үүсвэр болон инженерийн хангамжийн байгууллага, харьяа газар, дүүргүүд нийт 1356 арга хэмжээ төлөвлөснөөс 2020 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 95 хувийн гүйцэтгэлтэй байна.

Улаанбаатар хотын 1-14 магистраль шугамд нийт 9 зогсолт хийхээс 9 дэх засварын ажил төлөвлөгөөний дагуу хийгдэж, 2020 оны 9 дүгээр сарын 6-ны өдрийн байдлаар дулааны төв шугам тоноглол, насос станц, хэрэглэгчдийн шугам тоноглолын засварын ажил 99.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

Усан хангамж, цэвэрлэх байгууламжийн тоног төхөөрөмж, шугам хролойн барилга байгууламжийн их засварын 53, гэр хорооллын усан хангамжийн 12, цахилгаан хангамжийн 8, зохион байгуулалтын 10 ажил, нийт 83 ажил төлөвлөснөөс одоогоор 58 ажил бүрэн хийгдээд байна.

#### 4.2.Авто зам, тээвэр, тохижилтын чиглэлээр:

Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд Улаанбаатар хотын гол болон туслах 69 гудамж замд нийт 24,700 м<sup>2</sup> нөхөөсний ажил, 1749 ширхэг тэмдэг арчлалтын ажил, 1126,2 у/м хайс арчлалтын ажил, 20 гудамжинд 110,000 у/м авто замын ан цав, заадас арчлах ажил, 249,985 м<sup>2</sup> шороон зам хусч тэгшлэх ажлыг 100 хувьтай гүйцэтгэсэн байна.

Тэмдэглэгээний ажлын хувьд 98,039 м<sup>2</sup> тэмдэглэгээ хийхээс 79000 м<sup>2</sup> буюу 93 хувийн гүйцэтгэлтэй байна. Мөн 11 байршил дахь явган хүний нүхэн болон гүүрэн гарцын арчлалтын ажил, 3 байршилд төмөр зам доогуурх нүхэн гарцын арчлалтын ажлыг тогтмол хийж гүйцэтгэжээ.

Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч 20 аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах шатахуун, зайлшгүй шаардлагатай сэлбэг, шатах тослох материал, хөлддөггүй шингэн, спиртийн нөөцлөлт 90 хувьтай байна.

Түүнчлэн авто замын халтиргаа, гулгаанаас сэргийлэх хүрээнд шаардлагатай бодис, давсны нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд 2020 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн байдлаар “Хот тохижилтийн газар” ОНӨААТҮГ өөрийн хөрөнгөөр 400 тонн бодис, дүүргийн хувийн хэвшлийн зам цэвэрлэгээний байгууллагууд 140 тонн бодис, 289 тонн давс, зарим дүүрэг болон дүүргийн ОНӨААТҮГ-үүд 181 тонн бодис шинээр нэмж авчээ.

Мөн Нийслэлийн Засаг даргын захирамжаар 1023 тонн бодис, 666 тонн давс худалдан авах гэрээ хийгдэж, давсыг дүүргүүдэд хуваарилсан бол 2000 тонн бодис нөөцлөх хөрөнгө шийдвэрлэгдэж, 700 тонн бодис худалдаж аваад байна.

#### 4.3.Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр:

2020 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн байдлаар “Таван толгой түлш” ХХК-ийн баруун бүсийн сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийн тоног төхөөрөмжийн их засварын ажил 90 хувь, үйлдвэрийн тоосжилтыг багасгах ажил 65 хувь, гадна зам, талбайн бетон хучилтын ажил 75 хувийн гүйцэтгэлтэй байгаа бөгөөд нийт дүнгээр өвөлжилтийн бэлтгэл ажил 76 хувийн гүйцэтгэлтэй байна.

Мөн өдрийн байдлаар сайжруулсан шахмал түлшний түүхий эдийн (мидлинг) нөөц дундын агуулахад 386 мянган тонн, баруун бүсийн үйлдвэрийн хашаанд 53.9 мянган тонн, зүүн бүсийн үйлдвэрийн хашаанд 3.2 мянган тонн тус тус байгаа бөгөөд нийт 443.1 мянган тонн мидлингийн нөөцтэй байна. Үүнээс гадна нийслэлийн 6 дүүрэгт байрлах агуулах, цэгүүд болон үйлдвэрийн агуулахад нийт 84.3 мянган тонн мидлинг нөөцөлсөн болно.

2020 оны 9 дүгээр сарын 28-ний өдрийн байдлаар нийслэлийн зүүн бүсэд баригдаж байгаа шинэ үйлдвэрийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл 65 хувь, тоног төхөөрөмжийн угсралт 81 хувь, нийт ажлын гүйцэтгэл 64 хувьтай байгаа бөгөөд 2020 оны 11 дүгээр сарын 1-ний өдрийн дотор ашиглалтад оруулахаар ажиллаж байна.

Түүнчлэн Засгийн газрын 2020 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдаанаар агаарын бохирдлыг бууруулах зорилгоор аймгийн төв болон 10 мянгаас дээш хүн амтай сум, суурин газруудын гэр хорооллын хоёр тарифт тоолууртай өрхийн тухайн оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс дараа оны 3 дугаар сарыг дуустал 21:00-06:00 цагийн хооронд хэрэглэсэн цахилгааны төлбөрийг 100 хувь хөнгөлөхөөр шийдвэрлэлээ.

-----оо-----